



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐3.᠐᠑ № 199

танай _____-ы № _____-т


Г ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН Г
ГАЗРЫН ДАРГА Л.МЭНДБАЯР
ТАНАА

Танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5-р сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү

Хавсралт...*6*...хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

02560021

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл
Утас: 990407705

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт.....	0
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Албан шаардлага	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
6. Албан шаардлага.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 198

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны кол	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	241,653,422.58	1,053,208,560.08
33	АВЛАГА	3,210,000.00	7,440,000.00
335	Бусад авлага	3,210,000.00	7,440,000.00
3351	Байгууллагаас авах авлага	2,440,000.00	7,440,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	770,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	238,443,422.58	1,045,768,560.08
351	Түүхий эд материал	187,619,761.08	731,470,517.58
35130	Эм боох материал	187,619,761.08	731,470,517.58
354	Хангамжийн материал	50,823,661.50	314,298,042.50
35420	Аж ахуйн материал	12,059,961.50	274,934,342.50
35470	Бусад хангамжийн материал	38,763,700.00	39,363,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	904,768,263.02	915,562,993.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	904,768,263.02	915,562,993.71
392	Биет хөрөнгө	864,768,263.02	874,875,493.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	688,276,500.00	688,276,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,010,716.64)	(35,463,574.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	246,871,297.00	246,871,297.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(125,671,296.94)	(187,371,296.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,875,911.05	211,166,029.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(90,431,577.90)	(104,188,613.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,378,380.00	109,853,895.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(48,917,333.55)	(55,585,842.57)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,183,984.74	27,183,984.74
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,183,984.74)	(27,263,984.74)
39217	Ном	1,397,100.00	1,397,100.00
393	Биет бус хөрөнгө	40,000,000.00	40,687,500.00
39301	Програм хангамж	462,000.00	1,452,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(462,000.00)	(764,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,146,421,685.60	1,968,771,553.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,808,549.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,808,549.00	00.00
413	Өглөг	3,808,549.00	00.00
4136	Бусад өглөг	3,808,549.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,883,549.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	925,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,142,613,136.60	1,968,771,553.79
51	Засгийн газрын хувь оролцоо	1,142,613,136.60	1,968,771,553.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	876,621,728.80	876,621,728.80
51101	Өмч: - төрийн	876,621,728.80	876,621,728.80
512	Хуримтлагдсан үр дүн	250,750,643.88	1,076,909,061.07
51210	Өмнөх үеийн үр дүн	250,750,643.88	250,750,643.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	826,158,417.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,240,763.92	15,240,763.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,146,421,685.60	1,968,771,553.79

**Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,399,869,160.70	9,045,527,675.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	374,413,060.70	5,716,987,385.00
120	Нийтлэг татварын бус орлого	374,413,060.70	5,716,987,385.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	374,413,060.70	5,716,987,385.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	374,413,060.70	5,716,987,385.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,025,456,100.00	3,328,540,290.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,914,073,000.00	1,726,596,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,914,073,000.00	1,726,596,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,383,100.00	1,601,943,390.01
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,819,100.00	101,044,630.01
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,468,000.00	89,283,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,131,000.00	1,359,429,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,965,000.00	52,184,960.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,233,276,472.58	8,219,369,257.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,233,276,472.58	8,219,369,257.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,401,029,221.88	7,183,911,669.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,805,316.53	480,860,877.90
210101	Үндсэн цалин	316,581,418.52	309,526,402.13
210102	Нэмэгдэл	62,854,295.39	78,637,100.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,878,886.00	61,394,919.87
210104	Урамшуулал	42,490,716.62	31,302,455.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,536,301.99	66,379,469.04
210201	Тэтгэврийн даатгал	40,244,826.17	50,465,964.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,426,472.12	3,737,354.22
210203	УОМШО-ний даатгал	3,541,176.70	2,763,133.76
210204	Ажилгүйдлийн даатгал	854,720.44	617,194.06
210205	Эрүүл мэндийн даатгал	8,469,106.57	8,795,822.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,189,831.00	37,893,583.83
210301	Гэрэл, цахилгаан	7,295,891.00	6,193,781.83
210302	Тулш, халаалт	28,550,324.00	28,614,566.00
210303	Цэвэр, бохир ус	2,343,616.00	3,085,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,772,101.00	31,119,295.03
210401	Бичиг хэрэг	13,062,720.00	7,608,297.00
210402	Тээвэр, шатахуун	25,662,246.00	14,095,500.00
210403	Шуудан, холбоо, ингертнийн төлбөр	1,493,087.00	2,802,198.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,363,900.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	16,208,148.00	6,613,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	575,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	11,407,000.00	-
2105	Нормативт зардал	496,136,878.49	4,884,763,880.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	496,136,878.49	4,883,263,880.78
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,074,410.38	44,134,470.00
210601	Багаж, техник хэрэгсэл	22,000,000.00	40,611,670.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	2,500,000.00
210604	Урсгал засвар	54,074,410.38	1,022,800.00
2107	Томилголт, зочны зардал	7,120,000.00	5,281,300.00
210702	Дотоод албан томилголт	7,120,000.00	5,281,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,600,379.00	9,480,273.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,166,000.00	2,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	4,266,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,660.00	540,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,349,719.00	1,158,273.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	183,794,003.49	1,623,998,519.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	114,892,135.00	1,529,059,016.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	978,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,901,868.49	93,960,903.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	832,247,250.70	1,035,457,588.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	818,568,924.00	983,905,332.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	481,280,824.00	340,301,000.00
213208	Хөлөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	299,748,100.00	631,917,966.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,540,000.00	11,686,366.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,678,326.70	51,552,256.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,678,326.70	51,552,256.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	166,592,688.12	826,158,417.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,699,999.94	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,699,999.94	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(21,699,999.94)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	144,892,688.18	826,158,417.19

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	(22,959,605.57)	-	818,120,344.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,318,491.73	-	2,318,491.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	836,738,409.10	4,341,541.00	(20,641,113.84)	-	820,438,836.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(2,318,491.73)	-	-	(2,318,491.73)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	(116,680.30)	-	(610,428.45)	-	(727,108.75)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	250,750,643.88	-	1,142,613,136.60
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	250,750,643.88	-	1,142,613,136.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	250,750,643.88	-	1,142,613,136.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	826,158,417.19	-	826,158,417.19
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	876,621,728.80	15,240,763.92	1,076,909,061.07	-	1,968,771,553.79

**Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,025,456,100.00	3,328,540,290.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	2,025,456,100.00	3,328,540,290.01
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,914,073,000.00	1,726,596,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,914,073,000.00	1,726,596,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,383,100.00	1,601,943,390.01
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	79,819,100.00	101,044,630.01
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,468,000.00	89,283,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,131,000.00	1,359,429,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,965,000.00	52,184,960.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,994,996,100.00	3,309,020,390.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,994,996,100.00	3,309,020,390.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,161,568,849.30	2,273,562,801.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,130,726.91	481,015,877.92
210101	Үндсэн цалин	316,581,418.52	309,681,402.15
210102	Нэмэгдэл	62,854,295.39	78,637,100.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,878,886.00	61,394,919.87
210104	Урамшуулал	43,816,127.00	31,302,455.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,536,301.99	66,379,469.02
210201	Тэтгэврийн даатгал	57,395,752.99	49,066,732.15
210202	Тэтгэмжийн даатгал	140,549.00	4,037,155.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,229,724.41
210204	Ажигчидлийн даатгал	-	674,725.01
210205	Эрүүл мэндийн даатгал	-	9,371,131.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,189,831.00	38,552,583.83
210301	Гэрэл, цахилгаан	7,295,891.00	6,193,781.83
210302	Түлш, халаалт	28,550,324.00	28,594,566.00
210303	Цэвэр, бохир ус	2,343,616.00	3,764,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,945,653.00	28,080,595.03
210401	Бичиг хэрэг	3,606,620.00	5,364,140.00
210402	Тээвэр, шатахуун	18,759,446.00	15,064,700.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	1,493,087.00	3,010,355.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	2,412,300.00	2,476,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,674,200.00	2,165,000.00
2105	Нормативт зардал	329,526,122.40	22,316,566.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	328,326,122.40	20,816,566.97
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,327,500.00	55,269,670.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,090,000.00	40,869,370.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,031,600.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	53,205,900.00	11,900,300.00
2107	Төмилөлт, зочны зардал	7,120,000.00	5,281,300.00
210702	Дотоод албан томилолт	7,120,000.00	5,281,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,150,379.00	9,601,273.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,166,000.00	2,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	4,266,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,660.00	540,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,899,719.00	1,279,273.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,642,335.00	1,567,065,465.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	131,587,335.00	1,565,738,865.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,055,000.00	1,326,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	833,427,250.70	1,035,457,588.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	819,748,924.00	983,905,332.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	481,280,824.00	340,301,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	299,748,100.00	631,917,966.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,720,000.00	11,686,366.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,678,326.70	51,552,256.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,678,326.70	51,552,256.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,460,000.00	19,519,900.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,460,000.00	19,519,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,460,000.00	19,519,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,460,000.00	19,519,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,460,000.00	19,519,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(30,460,000.00)	(19,519,900.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,726,596,900.00	1,686,376,583.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,726,596,900.00	1,686,376,583.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,513,200.00	702,471,251.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468,925,700.00	460,410,925.92
210101	Үндсэн цалин	306,434,600.00	289,076,450.15
210102	Нэмэгдэл	76,100,900.00	78,637,100.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,425,000.00	61,394,919.87
210104	Урамшуулал	45,965,200.00	31,302,455.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,305,000.00	60,361,513.29
210201	Тэтгэврийн даатгал	44,547,900.00	43,048,776.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,689,300.00	4,037,155.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,751,400.00	3,229,724.41
210204	Ажилгүйдлийн даатгал	937,900.00	674,725.01
210205	Эрүүл мэндийн даатгал	9,378,500.00	9,371,131.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,718,000.00	38,552,583.83
210301	Гэрэл, цахилгаан	9,936,000.00	6,193,781.83
210302	Түлш, халаалт	34,714,700.00	28,594,566.00
210303	Цэвэр, бохир ус	4,067,300.00	3,764,236.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,068,600.00	24,832,435.03
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	4,374,180.00
210402	Тээвэр, шатахуун	12,807,200.00	12,806,500.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	3,076,200.00	3,010,355.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,476,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,185,200.00	2,165,000.00
2105	Нормативт зардал	3,536,000.00	3,408,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	2,000,000.00	1,908,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,536,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,459,500.00	72,249,570.00
210601	Багаж, техник хэргэсэл	52,751,000.00	52,719,270.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,708,500.00	7,630,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,900,300.00
2107	Томилголт, зочны зардал	7,920,000.00	5,281,300.00
210702	Догоод албан томилголт	7,920,000.00	5,281,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,944,000.00	10,591,273.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,800,000.00	2,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,364,000.00	4,266,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	540,000.00	540,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	2,269,273.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,636,400.00	26,782,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,553,500.00	25,456,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,082,900.00	1,326,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	984,083,700.00	983,905,332.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	984,083,700.00	983,905,332.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	340,301,000.00	340,301,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	632,082,700.00	631,917,966.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,700,000.00	11,686,366.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,726,596,900.00	1,686,376,583.45
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,726,596,900.00	1,686,376,583.45
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,726,596,900.00	1,686,376,583.45
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,601,943,390.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,601,943,390.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,611,450.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,604,952.00
210101	Үндсэн цалин	20,604,952.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,017,955.73
210201	Тэтгэврийн даатгал	6,017,955.73
2104	Хангамж, бараа материалын зардал	3,248,160.00
210401	Бичиг хэрэг	989,960.00
210402	Тээвэр, шатахуун	2,258,200.00
2105	Нормативт зардал	18,907,866.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,907,866.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,541,832,515.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,541,832,515.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,331,939.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,331,939.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,331,939.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,601,943,390.01
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,601,943,390.01
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	101,044,630.01
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,283,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,359,429,850.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,184,960.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 75 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн асуудлаар, хөтөлбөр, стратеги, төлөвлөлт хийх, шийдвэр гаргахад аймгийн засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.
2. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн үйл ажиллагааны бусад салбар, иргэдийн оролцоог хангах.
3. Хүн амын эрүүл мэндтэй холбогдон гарсан бодлого, хөтөлбөр, тушаал шийдвэрийг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллага болон орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж хэрэгжилтийг зохион байгуулах.
4. Эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн түвшинд эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах.
5. Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй, тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах, шийдвэрлэх чиг үүрэгтэй, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,233.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 22.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд тайлант онд нийт зардал өссөн тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 822.3 сая төгрөгөөр буюу 71.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,210.0	7,440.0	4,230.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	238,443.4	1,045,768.6	807,325.1
Үндсэн хөрөнгө	904,768.3	915,563.0	10,794.7
Нийт хөрөнгө	1,146,421.7	1,968,771.6	822,349.9
Өр төлбөр	3,808.5	-	(3,808.5)
Засгийн газрын сан /Орон нутгийн сан	876,621.7	876,621.7	-
Өмнөх үеийн үр дүн	250,750.6	250,750.6	-
Тайлант оны үр дүн		826,158.4	826,158.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,240.8	15,240.8	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,146,421.7	1,968,771.6	822,349.9
Нийт орлого /Үр дүнгийн тайлан	2,399,869.2	9,045,527.7	6,645,658.5
Нийт зардал /Үр дүнгийн тайлан	2,233,276.5	3,373,405.8	1,140,129.4

Авлага дансны үлдэгдэл 7.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд эрүүл мэндийн яамнаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,045.8 сая төгрөг болж 807.3 сая төгрөгөөр өссөн нь халдварт өвчний үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 915.5 сая төгрөг болж 10.8 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд 85.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө шилжиж ирсэн, батлагдсан төсвөөс 19.5 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 876.1 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 9,045.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,645.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 3,373.4 сая төгрөг болж, өмнөх оноос 1,140.1 сая төгрөгөөр буюу 51.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд улсын төсвөөс 1,726.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,726.6 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,686.4 сая төгрөгийг зарцуулж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 40.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас короновируст халдварын дархлаажуулалтын вакцины санхүүжилт, эрүүл мэндийн ажилчдад олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, илүү цагийн хөлс зэрэг нийт 1,359.4 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ашиглагдаагүй нөөц хөрөнгөөс

89.2 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 101.0 сая төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 52.2 сая төгрөг, нийт 1,601.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 1,590.6 сая төгрөгийн зардал гаргаж, 11.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

- ✓ Цалингийн зардлаас төлөх даатгуулагчийн 5.4 сая төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллаагүй байна;

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,503.9 сая төгрөгийн 43 мөнгөн гүйлгээ, зарлагын 2,752.7 сая төгрөгийн 103 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 80.5 сая төгрөгийн 6 мэдээ, мэдээллийг мэдээлээгүй, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулаагүй зэрэг нийт 6,337.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 2 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлсэн ба хэрэгжилт 60 хувьтай байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт, бараа материал, үндсэн хөрөнгийн орлого, зарлага, тооллого, тооцоо бодолт, үлдэгдлийг баталгаажуулсан эсэхийг анхаарах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,342.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 албан шаардлага хүргүүлээ.

4.1 Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,503.9 сая төгрөгийн 43 мөнгөн гүйлгээ, зарлагын 2,752.7 сая төгрөгийн 103 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 80.5 сая төгрөгийн 6 мэдээ, мэдээллийг мэдээлээгүй, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулаагүй зэрэг нийт 6,337.1 сая төгрөгийн зөрчил
2. Цалингаас суутгасан даатгуулагчийн 5.4 сая төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллаагүй; зэрэг зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АСУУДАЛ											
1	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар	1	5.4					1	5.4		
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ											
1	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар	1	6,337.1					1	6,337.1		
Дүн		2	6,342.5					2	6,342.5		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 121/А2370449
ХЭА 2022/26/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас төлөх даатгуулагчийн 5.4 сая төгрөгийн НДШ-ийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлж батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" -ыг баримталж ажиллаагүй байна.


Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга Л.Мэндбаяр, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 122/АДЗТ04Н9
ХТД - 2022/26/НА-СТТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3,503.9 сая төгрөгийн 43 мөнгөн гүйлгээ, зарлагын 2,752.7 сая төгрөгийн 103 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 80.5 сая төгрөгийн 6 мэдээ, мэдээллийг мэдээлээгүй, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулаагүй зэрэг нийт 6,337.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга Л.Мэндбаяр, нягтлан бодогч Ц.Алтан-Өлзий нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА



02306003